

АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР(2013-2016 ОН)

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Эрдэм боловсролтой Монгол хүн” 3 дугаар бүлэгт заасан “Монголын онцлог бүхий, олон улсын стандартад нийцсэн, хөрвөх чадвартай боловсролыг эх орондоо олж авах, эзэмшсэн мэдлэг, мэргэжлээрээ ажил, хөдөлмөр эрхлэх боломжтой байх, эх орны хөгжлийн ирээдүй монгол хүнээ сургаж бэлтгэх” нь боловсролын салбарын гол зорилт болж байна.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, “Боловсрол” үндэсний хөтөлбөр, Боловсрол, шинжлэх ухааны яамнаас дэвшүүлсэн “Боловсролын чанарын шинэчлэл”, “Ном”, ”Авъяас”, “Багшийн хөгжил” хөтөлбөрүүд, аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан орон нутагт боловсролын чанарын шинэчлэлийг хэрэгжүүлэх нь энэхүү хөтөлбөрийн эрх зүйн үндэслэл болно.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Боловсрол, соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, бие даан сурч, ажиллах чадвартай, үндэсний уламжлал, соёл, зан заншлаа дээдэлдэг, эрдэм боловсролтой иргэнийг төлөвшүүлэхэд оршино.

ГУРАВ. БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.

3.1.Хөтөлбөр нь боловсролын хөгжлийн түвшин, эрэлт хэрэгцээ, сонирхол, боломж, итгэл үнэмшилд тулгуурлах

3.2.Боловсролын тухай хууль болон холбогдох бусад бодлогын баримт бичиг, хөтөлбөртэй нийцсэн байх

3.3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь нээлттэй, хүртээмжтэй, уян хатан чанартай, шударга, тэгш байх, хөгжлийн чиг хандлага, үндэсний болон орон нутгийн онцлогт нийцсэн байдлыг хангасан байх

3.4.Хөтөлбөр нь олон улсын

3.5.Төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн оролцоо, иргэд гадаадын хандивлагч, сонирхогч бүх талын дэмжлэгт түшиглэх

3.6.Мэдээлэл, харилцааны технологийн ололт амжилтыг ашиглах

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТУУД

4.1.Оюутан, сурагч, хүүхэд бүрийн авьяасыг нээх, хөгжүүлэх төлөвлөгөөг орон нутгийн онцлогтой уялдуулан хэрэгжүүлэх

4.2.Иргэд, оюутан, сурагчид , хүүхэд багачуудад бүтээлчээр уншуулах арга зүйг эзэмшүүлэх

4.3.Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх

4.4.Боловсрол, соёлын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг сурталчлах, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах

4.5.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байр, соёлын байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх

4.6.Цэцэрлэг, сургууль төвт хөгжлийн менежментийг боловсронгуй болгож сургууль, цэцэрлэгийн нөөцөд суурилсан өрсөлдөөнийг дэмжих

4.7.Насан туршийн боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэн иргэдэд амьдрах ухааны боловсрол олгох

4.8.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлж, СӨБ-ийн болон суурь боловсролын хамрах сургалтыг нэмэгдүүлэх

4.9.Дотуур байрны орчин нөхцлийг сайжруулах, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх

4.10. Олон үндэстэн, ястны өвөрмөц зан заншил, хэл, соёл, урлагийн үнэт өвийг хүүхэд багачуудад өвлүүлэх

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

Хөтөлбөрийг Монгол Улсын шинэчлэлийн Засгийн газар, Боловсролын чанарын шинэчлэлийн бодлого, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан 2013-2016 онд хэрэгжүүлнэ.

ЗУРГАА. ХАМРАХ ХҮРЭЭ

- Хүүхэд, багачууд, оюутан, сурагчид
- Багш, сурган хүмүүжүүлэгчид, мэргэжилтэн, ажилтан, албан хаагчид

- Иргэд
- Төр, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд

ДОЛОО. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

7.1.Зорилт 1-ийн хүрээнд дараах үйл ажиллагаа зохион байгуулна.

7.1.1.Орон нутгийн онцлогтой уялдуулан “Авьяас” хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлуулан хэрэгжүүлэх

7.1.2.Багш сурган хүмүүжүүлэгч, олны танил алдартай хүмүүс, авьяаслаг иргэдээр удирдуулсан дугуйлан, секц, клубын үйл ажиллагааг арга зүйгээр хангах, дэмжих

7.1.3.Орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдийн дунд /ТВ, сонин/ "Хүүхэд хөгжил-Шинэ санаачлага" уралдаан зохион байгуулах, урамшуулах

7.1.4.Үндэсний фестивальд оролцох бүтээлийг шалгаруулах, шалгарсан бүтээл, тэргүүний туршлагыг нийтэд сурталчлах зорилгоор хүүхдүүдийн туурвисан бүтээлээр аймгийн фестиваль жил бүр зохион байгуулах, тайлагнах

7.1.5.Хүүхэд залуучуудын авьяас чадварыг нээх, хөгжүүлэх сонгон, дугуйлан, клубыг тэдний сонирхол, хэрэгцээнд үндэслэн хичээллүүлэх, дэмжлэг үзүүлэх, сурталчлах

7.1.6."Их найрал-Ховд" хүүхдийн найрал дууны наадмыг жил бүр зохион байгуулах.

7.1.7.“Бэрс” оны шатрын үзүүлэх тоглолтуудыг жил бүр зохион байгуулах.

7.1.8.ЕБС, цэцэрлэгүүдэд зохион байгуулах боломжгүй, мэргэжлийн ур чадвар шаардагдах дугуйлан, секц хичээллүүлэх иргэдийг дэмжих

7.1.9."Хүүхдийн авьяасыг хөгжүүлэх боломж" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг жил бүр зохион байгуулах.

7.2 Зорилт 2-ын хүрээнд дараах үйл ажиллагаа зохион байгуулна.

7.2.1.Орон нутгийн онцлогтой уялдуулан “Ном” хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлуулан хэрэгжүүлэх

7.2.2.Сургуулийн өмнөх болон сургуулийн насны хүүхэд, их, дээд сургууль, коллежийн оюутан, иргэдэд ном унших сэдэл тэмүүлэл төрүүлэх, бүтээлчээр унших арга зүйг түгээн дэлгэрүүлэх, иргэд, төр иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог хангах, хөхиүлэн дэмжих

7.2.3.Номын баяр, номын чуулганыг жил бүр зохион байгуулах, тайлагнах

7.2.4. Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, эх орноороо бахархах, сургалтын цахим хэрэглэгдэхүүнтэй болох зорилгоор Ховд аймгийн байгалийн үзэсгэлэнт газруудын электрон цомог бүтээх

7.2.5. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Би ном унших дуртай” төсөл шалгаруулах, хэрэгжүүлэх, дэмжих

7.2.6. Хүүхдийн бүтээлээр шилдэг ном бүтээх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах

7.2.7. Сурагч, оюутнуудад зориулсан илтгэлийг олны танил хүмүүстэй хамтран зохион байгуулах

7.2.8. Ном хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санаачлага гаргасан иргэд, анги хамт олныг алдаршуулах, дэмжих

7.2.9. Шинэ номыг иргэдэд түргэн шуурхай хүргэх, уншигчдын тоог нэмэгдүүлэх, иргэдийн боловсрох хэрэгцээг хангах зорилгоор нүүдлийн номын сан ажиллуулах

7.3 Зорилт 3-ын хүрээнд дараах үйл ажиллагаа зохион байгуулна.

7.3.1 Орон нутгийн онцлогтой уялдуулан “Багшийн хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлуулан хэрэгжүүлэх

7.3.2 Бүх шатны боловсролын байгууллагын багшийн мэргэжил дээшлүүлэх хэрэгцээний судалгааг тогтмолжуулж, багшийг хөгжүүлэх чиг хандлага, эрэлт хэрэгцээнд тулгуурласан сургалт зохион байгуулах

7.3.3. Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, багшийн мэргэжил ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр, модуль, мэдээллийн болон хэрэглэгдэхүүний цахим сан бий болгох

7.3.4 “Багшийн хөгжил” сэдвээр олон нийтийн хэлэлцүүлэг, зөвлөгөөн, чуулга уулзалт, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулах

7.3.5 Багш ажлын байран дээрээ мэргэжил, арга зүй, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд багшийн хөгжлийн төвүүдэд арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээ, мэдээллээр хангах, ном, гарын авлага, цахим хичээл, цахим сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтын шинэлэг арга, тэргүүн туршлагаар дэмжих

7.3.6 Хүүхэд бүрийн авьяасыг нээн хөгжүүлэх чиглэлээр теле нэвтрүүлэг, интернэт, цахим хуудас нээн ажиллуулах

7.3.7 Боловсрол, соёлын газрын дэргэд мэргэжлийн багш нарын залгамж холбоог бэхжүүлэх, сургалтын чанарыг сайжруулах зорилгоор орон тооны бус

мэргэжил, арга зүйн зөвлөлийг байгуулан үйл ажиллагааг тогтмолжуулах, урамшуулах

7.3.8 Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх арга барилыг боловсруулсан багш нарын бүтээл, тэргүүн туршлагыг тодорхой шалгуур үзүүлэлтээр үнэлж, урамшуулах, нийтийн хүртээл болгох

7.3.9 Бүтээлч үйл ажиллагаагаараа манлайлж буй сургуулийн багш нарыг бусад сургуульд гэрээний үндсэн дээр солилцоогоор ажиллуулах, харилцан туршлага судлуулах

7.3.10 Багш мэргэжлээр суралцах хүсэлттэй төгсөх ангийн сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгоор “Багш” сонгон хичээллүүлэх

7.3.11 Хүүхдийг хөгжүүлэгч, бүтээлч, багш нарыг дотоодын болон гадаадын сургалтын байгууллагын туршлага судлуулах, бусдад түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг тооцох

7.3.12 Боловсролын удирдах ажилтан, мэргэжилтний хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх

7.3.13 Боловсрол, соёл, урлагийн байгууллага, суралцагч, багш, ажилтны дунд хэлэлцүүлэг, олимпиад, уралдаан тэмцээн зохион байгуулах, сурталчлах, тайлагнах

7.3.14 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах, хөгжүүлэх багш нарыг бэлтгэх

7.4 Зорилт 4-ийн хүрээнд дараах үйл ажиллагаа зохион байгуулна

7.4.1.Засгийн газар болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан боловсрол, соёлын талаар дэвшүүлсэн зорилт, бодлого чиглэлийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, гүйцэтгэлийг дүгнэж, тайлагнах, мэдээлэх

7.4.2.Боловсрол, соёлын салбарт хэрэгжиж буй хууль, тогтоол, хөтөлбөр, шийдвэрийг салбарын байгууллагуудад хэрэгжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, биелэлтэнд хяналт тавих, үр дүнг тооцох, тайлагнах

7.4.3.Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол, “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх, иргэд олон нийтийн оролцоог хангах, хяналт тавих, тайлагнах

7.4.4.Олон улсын төсөл, хөтөлбөрийн байгууллага, орон нутгийн иргэд, олон нийтийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан боловсролын салбарыг хөгжүүлэхэд үйл ажиллагааг чиглүүлэх, тайлагнах

7.4.5.Төрийн албаны болон багшийн ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг байгууллага болон салбарын байгууллагуудад зохион байгуулах, хариуцлага тооцох, хэрэгжилтэнд хяналт тавих, тайлагнах

7.4.6.Иргэд, олон нийтийн байгууллагын өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх

7.4.7.Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг дүрэмт хувцсаар хангах ажлыг зохион байгуулах, тайлагнах

7.4.8.Багш, ажилтан, мэргэжилтэн, суралцагчийн хөдөлмөрийг бодитой үнэлж шагнаж урамшуулах, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх

7.4.9.Бүх шатны боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагаа, төсөв, санхүүгийн зарцуулалт, гүйцэтгэлийг олон нийт, эцэг эх, иргэдэд ил тод, нээлттэй болгох боломжит арга хэмжээ авах, шийдвэр гаргах үйл явцад тэдний оролцоог бий болгох механизмыг бүрдүүлэх

7.4.10.Боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудитын тогтолцоог нэвтрүүлэх

7.4.11.Сургууль, цэцэрлэгт хүүхэд элсүүлэхэд хандив, хууль тогтоомжид зааснаас бусад төлбөр, хураамж авах, Боловсрол, шинжлэх ухааны яамнаас зөвшөөрөл олгоогүй сурах бичиг, ном, гарын авлага болон бусад сургалтын материал, сонин, үзвэрийн билет зэргийг сурагчдад албадлагаар худалдан авахыг шаардахгүй байх, энэ төрлийн зөрчил гаргуулахгүй байх талаар урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах

7.4.12.Хүүхдийг архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэх, донтох болон зан суртахууны буруу зуршилд автахаас сэргийлэх талаар орон нутгийн мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах

7.4.13.Хүүхдийн эрхийг дээдлэн, сургалтын байгууллагын үйл ажиллагаанд хүүхдийн оролцоог хангах

7.4.14.Боловсролын салбарын ажиллагсад, оюутан, хүүхэд, багачуудыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулж, мэдээллийн сан бүрдүүлэх

7.4.15.Салбарын байгууллагын төсвийн төсөл, төсвийн зарлага, санхүүжилтийн гүйцэтгэлийн тайланг гаргуулан үнэлгээ өгөх, тайлагнах

7.4.16."Оюунлиг-Ховд" хөтөлбөрийн хүрээнд "Хөдөлгөөн-Эрүүл мэнд", "Амны хөндийн-Эрүүл мэнд" аяныг жил бүр зохион байгуулах, тайлагнах

7.4.17.Эко сургуулиудын сүлжээг өргөтгөж, хүүхэд, иргэдэд байгаль орчин тогтвортой хөгжлийн мэдлэг, боловсрол олгох, сургууль, цэцэрлэгийн ногоон

орчныг нэмэгдүүлэх, байгаль хамгаалах үйл ажиллагаанд боловсролын байгууллагуудыг татан оролцуулах

7.4.18.Ховд их сургууль, Хөгжил Политехник коллежийг түшиглэн инноваци технологийн төвийг байгуулж, их, дээд сургуулиудын хотхон байгуулах ажлыг дэмжих

7.5 Зорилт 5-ын хүрээнд дараах үйл ажиллагаа зохион байгуулна.

7.5.1.Боловсрол, соёлын салбарын хөрөнгө оруулалтын мэдээллийн сан бүрдүүлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах

7.5.2.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиудад урлаг, спорт болон бусад төрлийн дугуйлан, секц хичээллүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгаа гарган дэмжих

7.5.3.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, соёлын төвийн хэрэгцээнд үндэслэн номын фонд баяжилт хийх, цахим номын сантай болгох

7.5.4.Багш-хүүхэд-эцэг, эх хөгжих боломж бүхий баруун бүсийн “Багшийн хөгжлийн ордон” байгуулах

7.5.5.Сургууль, цэцэрлэгийн “Багшийн хөгжлийн төв”-ийг багш нарын бие дааж мэргэжил мэдлэгээ тасралтгүй дээшлүүлэх, хөгжих нөхцлөөр хангах, дэмжлэг үзүүлэх

7.5.6.Сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагын мэдээлэл харилцааны технологийн тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлж, интернэтэд холбох

7.5.7.Сургууль, цэцэрлэг, дотуур байр, спорт заалны барилга шинээр барих, өргөтгөх, засварлах, сургалтын байгууллагын тавилга, тоног төхөөрөмж, тоглоом наадгайг шинэчлэх дунд хугацааны төлөвлөлт хийж хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах, тайлагнах.

- Булган сумын I, Дөргөн, Үенч, Чандмань, Жаргалант сумын I, Цаст-Алтай цогцолбор сургууль, Ховд, Мөнххайрхан, Дуут сумын сумын сургуулийн барилгыг шинээр барина.

- Булган сумын I, Мөст, Жаргалант, Дуут, Дөргөн, Мөнххайрхан, Чандмань Дарви, Мянгад сумдын сургуулийн дотуур байрны барилгыг шинээр барина.

- Мөст, Жаргалант сумын 1,2, 4, 13 дугаар, Булган, Цэцэг, Үенч, Чандмань, Зэрэг сумдын цэцэрлэгийн барилгыг шинээр барина.

- Булган Ховд суманд спорт заалны барилга шинээр барина.

- Булган сумын I, II, Буянт, Мөст, Үенч Дөргөн, Дуут, Цэцэг, Зэрэг, Дарви, Манхан, Мөнххайрхан, Жаргалант сумын 1,2,3 дугаар, Цаст Алтай цогцолбор сургуулийн барилгуудыг шинэчилж барина

- Цэцэг, Мянгад, Мөнххайрхан, Үенч, Ховд, Булган, Эрдэнэбүрэн, Зэрэг, Жаргалант 3,4, 5, 6, 7,8, 10,11,12 дугаар цэцэрлэгийн барилгуудыг шинэчилж барина.
- Жаргалант сумын 9 дүгээр цэцэрлэгийн өргөтгөл барина.
- Сургууль, цэцэрлэгийн ширээ сандлыг шинэчлэх
- Сургууль, цэцэрлэгийн тоглоом наадгайг шинэчлэх

7.5.8.Музей, хөгжимт драмын театрын барилгыг шинээр барих, сумдад орон нутаг судлах танхим байгуулах ажлыг дэмжих

7.5.9.Нийтийн номын сангийн барилгын өргөтгөл, их засвар хийх, цахим болон нүүдлийн номын сан байгуулах

7.5.10.Жаргалант, Үенч, Дөргөн сумын спорт, соёл урлагийн цогцолбор, Буянт суманд соёлын төвийн барилгыг шинээр барих, Булган, Дарви, Дуут, Ховд сумын соёлын төвийн барилгуудад засвар хийх

7.5.11.Ерөнхий боловсролын сургуулийг байгалийн ухааны лабораторитой болоход дэмжлэг үзүүлэх

7.5.12.Сургууль, цэцэрлэгийн орчин дахь хоол, хүнс, ундны цэвэр ус, бие засах газрын эрүүл ахуй, аюулгүй байдлын баталгааг хангах, тэдгээрийг стандартын дагуу засварлан тохижуулах, сайжруулах ажлыг дэс дараатай хэрэгжүүлэх, тайлагнах

7.5.13.Боловсрол, соёлын байгууллагуудын эзэмшил газрыг баталгаажуулах ажлыг зохион байгуулах

7.5.14.Сургууль, цэцэрлэгийн биеийн тамирын болон тоглоомын талбайг тохижуулах, ногоон орчныг бий болгоход дэмжлэг үзүүлэх

7.5.15.Суралцагчдыг сурах бичгээр хангах ажлыг зохион байгуулах, тайлагнах

7.5.16.Сургалтын тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах шинэ санаачлагыг сургалтын байгууллагад нэвтрүүлэх

7.6 Зорилт 6-ийн хүрээнд дараах үйл ажиллагаа зохион байгуулна.

7.6.1.Аж ахуйн нэгж, иргэдэд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулахад хуулийн хүрээнд дэмжлэг үзүүлэх

7.6.2.Аймгийн тэргүүний сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагыг шалгаруулах журмыг боловсруулан хэрэгжүүлж бие даан хөгжих шударга өрсөлдөөнийг бий болгох

7.6.3.Аймгийн төв, зарим сумуудад сургууль, цэцэрлэгийн цогцолбор байгуулах

7.6.4 Үндэсний лаборатори сургуулийн үйл ажиллагааг бэхжүүлж сургалтын дэвшилтэт технологийг орон нутгийн онцлогтой уялдуулан нэвтрүүлэх

7.6.5.Боловсрол, соёлын байгууллага, тэдгээрт ажиллагсдын үйл ажиллагаанд хяналт тавих, дүгнэлт гаргах, аттестатчлах

7.6.6.Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд өөрийн болон иргэдийн хөндлөнгийн үнэлгээг бий болгож сургалтын байгууллагуудын бүтээлч санаачлагуудыг дэмжих

7.6.7.Сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг хууль тогтоомжинд нийцүүлэн хамт олон, эцэг, эх, суралцагчдын оролцоотой ил тод зарчмаар сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах

7.6.8.Сургууль, цэцэрлэгт цахим үйлчилгээг нэвтрүүлэх санаачлагыг дэмжих

7.7 Зорилт 7-ийн хүрээнд дараах үйл ажиллагаа зохион байгуулна

7.7.1.Насан туршийн боловсрол олгох орон нутгийн оновчтой тогтолцоо бий болгох

7.7.2.“Гэгээрэл” төвийн үйл ажиллагааг өргөтгөн насан туршийн боловсролын чиг үүргээр ажиллуулах, үйл ажиллагааг чанаржуулах, бие даасан байр, танхимтай болгоход дэмжлэг үзүүлэх

7.7.3.Насан туршийн боловсролын багш нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах, мэргэшүүлэх, дэмжих

7.7.4.Сургууль завсардсан болон сургуульд огт ороогүй хүүхэд, залуучуудыг “Суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөр”-ийн сургалтад хамруулах замаар боловсрол нөхөн олгох, ЕБС-д шилжүүлэн суралцуулах ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах

7.7.5.Насан туршийн боловсролын хэрэгцээний судалгаа, мэдээллийн сан бүрдүүлэх

7.7.6.Насан туршийн боловсрол олгох үйл ажиллагаанд иргэд, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, санаачлагыг дэмжих, урамшуулах

7.7.7.Орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдийг насан туршийн боловсрол, олгох үйл ажиллагаанд татан оролцуулах

7.8 Зорилт 8-ын хүрээнд дараах үйл ажиллагаа зохион байгуулна.

7.8.1.Сургуулийн өмнөх болон сургуулийн насны хүүхдийн цахим мэдээллийн сан бүрдүүлэх, хяналт шинжилгээ хийх, дүгнэлт гаргах

7.8.2.Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд бүрэн шилжүүлэх

7.8.3.Хүүхэд харах, асрах үйлчилгээ нээж ажиллуулахыг дэмжих, арга зүйгээр хангах

7.8.4.Малчин, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн цэцэрлэгийн насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах боломжийг бүрдүүлэх, багийн “Гэр” цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааг өргөтөн насан туршийн боловсролын чиг үүргээр хамтран ажиллах

7.8.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулан сургах орчин нөхцлийг сайжруулах, тэдний тусгай хэрэгцээнд тохирсон зориулалтын сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх

7.8.6.Цэцэрлэгт 5 настай хүүхдийг бүрэн хамруулах

7.8.7.Ерөнхий боловсролын сургуульд 6-14 насны хүүхдийг бүрэн хамруулах

7.8.8.Хүүхэд, багачууд сургууль, цэцэрлэгт баяр хөөртэй явах ээлтэй орчинг бий болгох

7.8.9.Жаргалант сумын хамран сургах тойргийг шинэчлэн тогтоох

7.9 Зорилт 9-ийн хүрээнд дараах үйл ажиллагаа зохион байгуулна.

7.9.1.Дотуур байрын багш, ажиллагсдыг чадваржуулахад төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах, хамтын ажиллагааг өргөжүүлэх

7.9.2.Дотуур байрын хүүхэд хөгжлийн төвүүдийн үйл ажиллагааг хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд чиглүүлэх, дэмжлэг үзүүлэх

7.9.3.Дотуур байрын үйл ажиллагаанд үнэлгээний шинэ аргачлалыг хэрэгжүүлэх, хүүхдэд ээлтэй үйлчилгээг нэвтрүүлэх

7.9.4.Аймгийн төвд үндэсний лаборатори, гүнзгий сургуулийг түшиглэн дотуур байр барих асуудлыг судлан шийдвэрлүүлэх

7.9.5.Дотуур байрын багшийн ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолтыг батлан мөрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэшүүлэх, дэмжих

7.9.6.Дотуур байрын хүүхдийн тоог нэмэгдүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх

7.9.7.Дотуур байр, хүүхэд хамгаалал, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнийг ажиллуулах

7.10 Зорилт 10-ын хүрээнд дараах үйл ажиллагаа зохион байгуулна.

7.10.1.Олон үндэстэн, ястны хэл, соёл, урлагийн үнэт өвийг өвлүүлэх, хадгалах, хамгаалах, баяжуулан хөгжүүлэх “Алтан өв” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх

7.10.2.Морин хуур, уртын дуу, бий биелгээ, монгол хөөмий, яруу найраг, тууль, цуур, айтыс, олон үндэстэн, ястны урлаг соёлын наадмыг тусгай хөтөлбөрөөр, “Авъяаслаг Ховдчууд” урлагийн наадмыг аймгийн Засаг даргын ивээл дор тус тус зохион байгуулах

7.10.3.Иргэдэд үндэсний өв соёлоо дээдлэх, хайрлан хамгаалах, өсвөр хойч үедээ уламжлуулахад “Өв соёлын хүрээлэн”-гийн үйл ажиллагааг чиглүүлэх, дэмжих

7.10.4.Түүх дурсгалын газрууд, биет болон биет бус өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулан фото болон цахим бүртгэлийн сан бүрдүүлэх

7.10.5.Соёл, урлагийн салбарын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, соёл урлагийн байгууллагын ажилтнуудын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, мэргэжилтэй боловсон хүчнээр хангах бодлогыг хэрэгжүүлэх

7.10.6.Биет бус өвийг тээгчдийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэх, хамгаалах зорилгоор "Соёлын өвийн гайхамшиг" Соёлын биет бус өв тээгчдийн хамтлаг байгуулах

7.10.7.Ховд аймгаас төрөн гарсан алдартнуудын музей байгуулах

7.10.8.Соёл, урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог дэмжиж хамтын ажиллагааг бэхжүүлэх, урамшуулах.

НАЙМ. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖИЛТИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

8.1 .Хөтөлбөрийг дараах байдлаар зохион байгуулна.

8.1.1.Хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах бодлого, эрхзүйн орчин бүрдүүлэх, иргэд, иргэний нийгмийн байгууллага, төр болон төрийн бус байгууллагуудын оролцоо уялдаа холбоог хангах, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийн хяналт–шинжилгээ, үнэлгээ хийх, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх асуудлыг Боловсрол, соёлын газар хариуцна.

8.1.2.Хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийн мониторингийн судалгааг Боловсрол,соёлын газар , ХоИС, “Хөгжил” политехник коллеж, иргэний нийгмийн төлөөлөл, орон тооны бус арга зүйн зөвлөл хамтран хэрэгжүүлнэ.

8.1.3.Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулах сургалт, сурталчилгааны ажлын агуулга, арга зүй, санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Боловсрол, соёлын газар боловсруулж, Засгийн газар, БШУЯ, ССАЖЯ, аймаг, орон нутгийн удирдлага, боловсрол, соёлын салбарын байгууллагууд, иргэний нийгмийн байгууллага, төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

ЕС. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ШАЛГУУР

Хөтөлбөрийн хэрэгжилтийг төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрэх үр дүн болон шалгуур үзүүлэлтийн биелэлтээр гаргана

Зорилт 4.1 хүрээний шалгуур үзүүлэлт

- Хөтөлбөрийн хугацаанд дугуйлан, секц, клубт хамрагдсан хүүхдийн
- Дугуйлан, секцийг удирдсан хүүхэд, багш, сайн дурын хүмүүсийн тоо
- Зохион байгуулагдсан фестиваль, эрдэм шинжилгээний бага хурал, сонгон, дугуйлан, секц, клубын тоо, сургалтын чанар
- Хүүхдүүдийн бүтээсэн уран бүтээлийн төрөл, тоо, чанар
- Хүүхэд бүрийн авьяасыг нээж, хөгжүүлсэн байдал
- Шинэ санаачлагуудын сан бүрдсэн байх
- Энэ зорилтыг хэрэгжүүлэхэд зарцуулсан төсвийн хэмжээ

Зорилт 4.2 хүрээний шалгуур үзүүлэлт

- Ном уншсан нийт хүүхдийн тоо
- Багш, эцэг эхчүүд, сурагч, оюутнууд ном унших бүтээлч арга зүй эзэмшсэн байдал
- Номын чуулганд ирүүлсэн хүүхдийн уран бүтээлийн тоо
- "Номын чуулган"-д оролцсон хүний тоо
- Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулийн номын санд нийлүүлсэн номын тоо

Зорилт 4.3 хүрээний шалгуур үзүүлэлт

- Багш нарын хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх арга зүй технологийн хөгжилд зориулсан хөтөлбөр үйл ажиллагаа
- Багш нарын хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх арга зүй технологийн хөгжилд зориулсан сургалтын тоо, хамрагдсан багш нар чанар үр дүн

- Багш нарын хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх арга зүй технологийн хөгжилд зориулсан санхүүжилтийн хэмжээ

- Мэргэжилтний хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн
- Мэдээллийн сангийн баяжилт

Зорилт 4.4 хүрээний шалгуур үзүүлэлт

- Боловсрол, соёлын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг сурталчилах үйл ажиллагааны тоо
- Хэрэгжилтийг хянан зөвлөсөн байдал, түүнд хамрагдсан байгууллага, хүний тоо, зарцуулсан төсөв хөрөнгийн хэмжээ
- Иргэдийн судалгааны үр дүн
- Иргэд, хүүхэд багачуудын оролцоо хангагдсан байдал
- Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тооны бууралт
- Багшийн ёс зүйн зөрчлийн тооны бууралт
- Төсвийн зарцуулалтын үр дүн
- Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан багш, ажилтан, хүүхдийн тоо, мэдээллийн сан бүрдсэн байх
- Эко сургуулийн сүлжээнд хамрагдсан сургуулийн тоо
- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид стандарт шаардлагад нийцсэн дүрэмт хувцасны хангалтын хувь
- Хүүхдийн амны хөндийн өвчлөл буурсан байна.
- Бие бялдарын сорилыг авч хэвшсэн байна.

Зорилт 4.5 хүрээний шалгуур үзүүлэлт

- Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байр, соёлын байгууллагын материаллаг баазыг бэхжүүлсэн зардлын хэмжээ
- Сургууль, цэцэрлэгийн эрүүл, аюулгүй орчин бүрдүүлсэн байдал
- Нийлүүлсэн тоног, төхөөрөмжийн тоо, зарцуулсан төсөв
- Сургууль, цэцэрлэг, дотуур байр, спорт заалны барилга шинээр барих, өргөтгөх, засварласан барилгын тоо, чанар, суудлын тоо
- Нийлүүлсэн цахим номын сангийн тоо
- Фонд баяжилт хийсэн номын тоо
- Нийлүүлсэн байгалийн ухааны лабораторийн тоо
- Тохижуулсан талбайн тоо
- Шинэчилсэн зөөлөн хатуу, эдлэлийн тоо
- Интернетэд холбогдсон сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагын тоо

- Нийлүүлэгдсэн компьютер, ухаалаг самбарын тоо
- Сурах бичгийн хангалтын хувь
- Соёлын байгууллагын суудлын тоо
- Үйлчилгээний чанар, хүртээмж
- Сургалтын тоног төхөөрөмжийг ашиглах шинэ санаачлагууд нэвтэрсэн байх

Зорилт 4.6 хүрээний шалгуур үзүүлэлт

- Байгуулагдсан сургууль, цэцэрлэгийн тоо
- Аймаг болон улсын тэргүүний сургууль, цэцэрлэгийн тоо
- Аттестатчилсан байгууллага, ажилтны тоо
- Иргэдийн оролцоо хангагдсан байдал
- Үнэлгээний шинэ аргачлал нэвтэрсэн байдал, үр дүн
- Үйлчилгээний чанар

Зорилт 4.7 хүрээний шалгуур үзүүлэлт

- Насан туршийн боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийн тоо
- Гэгээрэл төвүүдийн үйл ажиллагаа тогтмолжсон байдал
- Улсын болон орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгө, материалаг тусламж дэмжлэг
- Иргэд, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, санаачлагыг дэмжих, урамшуулсан зардлын хэмжээ
- Ерөнхий боловсролын сургуульд шилжин суралцагсдын тоо
- Суурь , бүрэн дунд боловсрол эзэмшсэн иргэдийн тоо
- Хүн амын боловсролын ерөнхий түвшинг дээшлүүлэх чиглэлийн сургалтын тоо, хамрагдсан иргэдийн тоо, чанар
- Хүн амд мэргэжлийн ур чадварын дээшлүүлэх чиглэлийн сургалтын тоо, хамрагдсан иргэдийн тоо, чанар
- Бичиг үсгийн боловсрол олгох сургалтын тоо, тайлагдалтын түвшин

Зорилт 4.8 хүрээний шалгуур үзүүлэлт

- Сургуулийн өмнөх боловсролын болон суурь боловсролын хамран сургалтын хувийн өсөлт
- Сургуулийн өмнөх болон сургуулийн насны хүүхдийн цахим мэдээллийн сан бий болсон байна

- Хувийн өмчийн сургууль, цэцэрлэг байгуулах, хүүхэд харах, асрах үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн тоо
- Хувилбарт сургалтанд хамрагдсан хүүхдийн тоо зарцуулсан санхүүжилтийн хэмжээ ажиллах
- Боловсролын үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо
- Хүүхэд, багачуудад ээлтэй орчин бүрдүүлсэн сургууль, цэцэрлэгийн тоо

Зорилт 4.9 хүрээний шалгуур үзүүлэлт

- Дотуур байрын ажиллагсдыг чадваржуулахад зарцуулсан зардлын хэмжээ
- Хүүхэд иргэдээс авсан сэтгэл ханамжийн судалгааны дүн
- Аймгийн төвд байгуулсан дотуур байрны тоо
- Дотуур байрын мэргэжлийн багшийн хангалтын хувь
- Дотуур байранд амьдарч буй хүүхдийн тооны өсөлт

Зорилт 4.10 хүрээний шалгуур үзүүлэлт

- Сум бүрийн хөтөлбөрийн хэрэгжилт, зарцуулсан зардлын хэмжээ
- Зохион байгуулсан наадмын тоо, оролцогсдын тоо, зарцуулсан зардлын хэмжээ
- “Өв соёлын хүрээлэн”-гээр үйлчлүүлсэн иргэд, хүүхдийн тоо
- Хамгаалалтанд авсан биет болон биет бус өвийн тоо
- Цахим мэдээллийн сан бүрдүүлсэн байдал
- Соёл, урлагийн салбарын үйлчилгээнд хамрагдагсдын тоо, орлогын хэмжээ
- Урлагийн бүтээлийн тоо, чанар
- Мэргэжилтэй боловсон хүчний хангалтын хувь
- Мэргэжил дээшлүүлсэн ажилтны тоо
- Байгуулсан танхимын тоо, үйлчлүүлэгчдийн тоо
- Төрийн бус байгууллага, иргэдийг урамшуулсан зардлын хэмжээ

АРАВ. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖСЭНЭЭР ГАРАХ ҮР ДҮН

Хөтөлбөр хэрэгжсэнээр дараах үр дүнд хүрнэ.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрэх үр дүн болон шалгуур үзүүлэлтийн биелэлтээр гаргана. Үр дүнг тооцохдоо явцын болон хэсэгчилсэн үнэлгээг ашиглана.

Зорилт 4.1-ийн хүрээнд:

- Хүүхдийн авьяасыг нээх, хөгжүүлэх, сурах арга барил эзэмшүүлэх загвар бий болсон байна.
- Хүүхдийн бүтээлийн сантай болсон байна.
- Хүүхэд багачуудын авьяас чадварыг нээх, хөгжүүлэхэд иргэд, төр иргэний нийгмийн байгууллагын оролцоо хангагдсан байна.
- Хүүхэд бүр авьяасаа нээх, хөгжих орчин бүрдсэн байна
- Хэвлэл мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагаа шинэ санаачлагуудыг сурталчилж хэвшсэн байна.
- Хүүхдийн авьяасыг нээх, хөгжүүлэх аргазүйн сантай болсон байна.
- Сургууль, цэцэрлэг бүр мэдээллийн сантай болсон байна.

Зорилт 4.2-ын хүрээнд:

- Хүүхэд багачууд, оюутан, сурагч, иргэд ном унших арга зүйг эзэмшсэн байна.
- Хүүхдийн бүтээлийн номтой болсон байна.
- Иргэд, төр иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоо хангагдсан байна
- Ховд аймгийн байгалийн электрон цомогтой болсон байна.
- Сургууль, цэцэрлэгүүд бүтээлчээр ном унших арга зүйн сантай болсон байна.
- Нүүдлийн номын сангийн үйлчилгээ тогтворжсон байна.
- Хүүхдийн хэрэгцээг хангасан номтой болсон байна.

Зорилт 4.3-н хүрээнд:

- Багш бүр хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх арга зүйг эзэмшсэн байна.
- Мэргэжлийн багш нарын залгамж холбоог бэхжүүлэх, сургалтын чанарыг сайжруулах зорилгоор орон тооны бус мэргэжил, арга зүйн зөвлөлийн үйл ажиллагаа тогтворжино.
- Бие даан сурч, ажиллах чадвартай, үндэсний уламжлал, соёл, зан заншлаа дээдэлдэг, эрдэм боловсролтой иргэн төлөвшүүлж, сургалтын чанар дээшлэнэ.

- Боловсрол, соёлын байгууллагууд цахим мэдээллийн сантай болж, харилцан туршлага солилцох сүлжээ бий болно.
- Сургалтын үйл ажиллагаанд хүүхэд бүрийн оролцоо хангагдсан байна.
- Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэгч багш нарыг урамшуулах, үнэлэх, дэмжих хандлага тогтсон байна.

Зорилт 4.4-ийн хүрээнд:

- Боловсрол, соёлын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг сурталчлах үйл ажиллагаа тогмолжино.
- Сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагууд иргэд, хүүхэд багачуудад ээлтэй орчин бүрдүүлсэн байна.
- Сургалтын байгууллагын үйл ажиллагаанд иргэд, хүүхэд багачуудын оролцоо хангагдсан байна.
- Төсвийн ил тод, нээлттэй байдал хэрэгжсэн байна.
- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид стандарт шаардлагад нийцсэн дүрэмт хувцсаар 100 хувь хангагдана.
- Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол, “Үдийн цай” хөтөлбөрийн чанар сайжирч, зориулалтын гал тогоотой сургуулиуд “Үдийн хоол” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- ЕБС-иуд “Эко” сургуулийн сүлжээнд бүрэн хамрагдсан байна.
- Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирна.
- Багш, оюутан, хүүхэд багачуудын эрүүл мэндийн судалгааны сан бүрдсэн байна.

Зорилт 4.5-ын хүрээнд:

- Баруун бүсийн жишиг “Багшийн хөгжлийн ордон” –той болно.
- Сургууль, цэцэрлэгийн эрүүл, аюулгүй орчин бүрдүүлсэн байна.
- Соёлын байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоо 0.5 дахин нэмэгдэнэ.
- Сургуулийн нэг багшид ногдох хүүхдийн тоог 20-25 хүргэнэ.
- Цэцэрлэгийн нэг багшид ногдох тоог 23-д хүргэнэ.
- Сургуулийн ээлжийн коэффициентийг аймгийн төвд 1.3, хөдөө сумуудад 1.2 –т хүргэнэ.
- Сургууль, цэцэрлэгийн ширээ сандлыг бүрэн шинэчилнэ.
- Бүх сургууль байгалийн ухааны лаборатортой болсон байна.

- Сургууль, цэцэрлэг ногоон байгууламжтай болсон байна.
- Сургууль, цэцэрлэгийн гадна тоглоомын талбайг тохижуулна.
- Сургууль, цэцэрлэгийн зөөлөн эдлэлийг 100 хувь шинэчлэнэ.
- Бүх сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагыг интернетэд бүрэн холбоно.
- Сургууль бүрийг ухаалаг самбартай болгоно.
- Сурах бичгийн хангалтыг 100 хувьд хүргэнэ.
- Сургуулийн хүчин чадлыг 4816 суудлаар, цэцэрлэгийн хүчин чадлыг 1450 ороор, дотуур байрны хүчин чадлыг 650 ороор тус тус нэмэгдүүлнэ.
- Соёлын байгууллагын суудлын тоог 2280-аар нэмэгдүүлнэ.
- Сургууль, цэцэрлэгийн жорлон, угаалтуурыг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн тохижуулсан байна.
- Нэг компьютерт ногдох хүүхдийн тоог 5 болгоно.
- Сургалтын тоног төхөөрөмжийн ашиглалтын сайжруулах шинэ санаачлагын сан бий болж, үйлчилгээнд нэвтэрсэн байна.

Зорилт 4.6-ийн хүрээнд:

- Хүүхдэд ээлтэй тэргүүний сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагууд бий болно.
- Ажлын хариуцлага сайжирна.
- Сургууль, цэцэрлэгт цахим үйлчилгээ нэвтэрүүлж эхэлсэн байна.
- Өөрийн болон иргэдийн хөндлөнгийн үнэлгээ сургалтын байгууллагуудад хэрэгжсэн байна.
- Бүтээлч санаачлагууд бий болно.
- Иргэдийн оролцоо хангагдана.

Зорилт 4.7-ийн хүрээнд:

- Насан туршийн боловсрол олгох орон нутгийн тогтолцоо бий болж, үйл ажиллагаа нь тогтмолжино.
- Иргэд , төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа сайжирна.
- Хүн амын боловсролын түвшин дээшилнэ.

Зорилт 4.8-ын хүрээнд:

- Суурь боловсролын хамран сургалт 99 хувьд, СӨБ-ын хамран сургалт 86 хувьд хүрнэ.

- 6 настай хүүхдийн хамрагдалтыг 100 хувьд хүрнэ.
- Бага боловсролын хамран сургалтыг 99 хувьд хүргэнэ.
- Хүүхэд харах үйлчилгээ бий болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулна.
- Боловсролын цахим мэдээллийн сан бүрдсэн байна.

Зорилт 4.9-ийн хүрээнд:

- Дотуур байрын багш нарын арга зүй, хандлага эергээр өөрчлөгдсөн байна.
- Дотуур байрын хүүхдийн тоо 10 хувиар нэмэгдсэн байна.
- Хүүхдэд ээлтэй үйлчилгээ бий болно.
- Дотуур байрны үйлчилгээнд үнэлгээний шинэ аргачлал хэрэгжиж, иргэдийн оролцоо, санаачлага бий болсон байна.

Зорилт 4.10-ын хүрээнд:

Соёл, урлагийн байгууллагын мэргэжилтэй боловсон хүчний хангалтыг 80 хувьд хүргэнэ.

- Музейн үзмэрийн тоог 120 нэмэгдүүлнэ.
- Цахим мэдээллийн сан бүрдүүлнэ.
- Соёл, урлагийн салбарын үйлчилгээнд хамрагдагсдын тоог 0.5 дахин нэмэгдүүлнэ.
- Уран бүтээлийн санг 20-иор нэмэгдүүлнэ.
- Алдартнуудын танхим бий болсон байна.
- Соёлын үйлчилгээний чанар хүртээмж дээшилнэ.
- Соёлтой үйлчилгээг нэвтрүүлнэ.
- Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирна.
- Хүүхэд, багачуудад үндэсний уламжлал, соёл, зан заншлаа дээдлэх, бахархах үзэл төлөвшүүлэх орчин бүрдсэн байна.

АРВАН НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

- Улсын төсөв
- Орон нутгийн хөгжлийн сан

- Хандивлагч орон, олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санаачилгаар хуримтлуулсан хөрөнгө, зээл, тусламж, хандив
- Бусад эх үүсвэр

----- оОо -----